



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот


Монгол Улсын Засгийн газрын  
гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.2, 34.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын дотоодын хөрөнгийн зах зээл дээр нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 360.000 ширхэг, 3 сараас 1 жил хүртэлх хугацаатай, нийт 360,000,000,000 /гурван зуун жаран тэрбум/ төгрөгийн үнийн дүн бүхий өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТГТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.6-д заасны дагуу энэхүү тогтоолын 1-д заасан үнэт цаасны дотоодын үнэт цаасны зах зээлд арилжаалагдаж буй үйл явц болон арилжааны тайланг тухай бүр Хороонд ирүүлж, тайлагнаж байхыг Монгол Улсын Сангийн Яам /Ч.Улаан/-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

100004